

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.АМАРТҮВШИН

ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад худалдааны бодлогыг зөв тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд нь дэмжлэг үзүүлэх, идэвхжүүлэх, тэднийг хөхүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах асуудлыг судалж, шийдлийн санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллах шаардлагатай байна.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Үндэсний Аюулгүй Байдлын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/01 дугаартай “Хилийн боомтыг хаах тухай” зөвлөмж, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дугаартай “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” тогтоолын дагуу гадаад улсын иргэд, гадаад улсын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсад нэвтрүүлэх хөдөлгөөнийг хязгаарлаад багагүй хугацаа өнгөрлөө.

Цар тахлын улмаас улсын хил хаасантай холбоотойгоор агаарын зорчигч тээвэр хязгаарлагдаж, гадаад улсын иргэд, хөрөнгө оруулагчид, мэргэжилтнүүд, гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа тасалдсан байна. Түүнчлэн гадаадын эдийн засгийн өсөлт өмнөх жилийнхтэй харьцуулахад тодорхой хувиар буурсан энэ үед гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой боловсруулах, төлөвлөх, санхүүжүүлэх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, гадаад худалдааны бодлогыг зөв тодорхойлох шаардлага бий болоод байна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 2 заалттай байх бөгөөд нэгд нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, хоёрт нь тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Түр хороо байгуулах тухай тогтоол батлагдсанаар үүсэж болох улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дүнд хүрнэ:

Нэг.КОВИД-19 цар тахлын улмаас үүссэн одоогийн эдийн засгийн нөхцөл байдал нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөө, үүнийг даван туулахад шаардагдах шинэ гарц, боломжуудыг судлан санал боловсруулж, хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлно.

Хоёр.Гадаад худалдааны бодлогыг зөв тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд нь дэмжлэг үзүүлэх, идэвхжүүлэх, тэднийг хөхүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах асуудлыг судлах

Гурав.Шинээр гадаадын хөрөнгө оруулагчдыг татах арга зам, гадаадын хөрөнгө оруулагчдад таатай хууль эрх зүйн орчин, нөхцөлийг бий болгох талаар санал боловсруулна.

Дөрөв.Төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төрийн оролцоог оновчтой болгож, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Тав.Түр хороо нь иргэд, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллага, эрдэмтэн, судлаачид, мэргэжлийн байгууллага, дотоод, гадаадын шинжээчдийн дэмжлэг оролцоонд тулгуурласан санал, дүгнэлт боловсруулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хэрэгжүүлэх талаар цаашид шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Хууль санаачлагч